

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.08.29 - 2022.09.02/

2022.09.01

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 212-р тогтоолын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг 1 удаа зохион байгуулж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан-Уул аймгийн Хонгор сумын төвийн эмнэлэгийн өргөтгөлийн барилга ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2 барилгад олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан сум 9-р багт байрлалтай Ти Эм Ойл ХХК шатахуун түгээх станц - Дархан-Уул, Дархан сум, 14-р багт байрлалтай 7-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга - Дархан сум 12-р багт 320 хүүхдийн сургуулийн барилга - Дархан сум 12-р багт Миракплэнд ХХК Шинэ алхам сургуулийн өргөтгөлийн Б блок барилга
1	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 1 барилгад олгосон. Үүнд: Дархан-Уул аймаг, Хонгор сум, 1-р баг иргэн С.Энхтүвшингийн үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн цахилгаан хангамжийн шугам ✓ Дархан сумын 3-р багт хийгдэх сайжруулсан шороон замын зураг ✓ Засаг даргын 6 бодлогын төлөвлөгөөнд санал хүргүүлсэн. ✓ Дархан сумын 7-р багийн нутаг дэвсгэрт байрлах 1-р сургуулийн урд талын замын трассд орсон айл өрхүүдтэй уулзаж газар чөлөөлөх талаар тохиролцсон.
	Барилгын лабораторын шинжээч	<ul style="list-style-type: none"> ✓ Дархан сумын багуудын багийн хөгжлийн төвийн байршлын зураг 10 ш ✓ Ажлын зураг 1-г хянаж баталгаажуулсан ✓ Загвар зураг 2-г хянаж баталгаажуулсан ✓ Архитектур төлөвлөлтийн даалгавар 1 боловсруулан хянуулж баталгаажуулсан
Газрын удирдлагын хэлтэс		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	<p>Захиалгат хянан баталгааны 29 тайлан хянаж баталгаажуулсан. 4 тайлдан хянаж буцаасан. 8-р сард баталгаажсан нийт тайлангийн тоон мэдээг агентлагт хүргүүлсэн. 6 нэгж талбарын мэдээллийг мэдээллийн санд нөхөж оруулсан. 2 иргэнд хариу тайлбар хүргүүлсэн. 1 иргэнд шаардах хуудас өгч ажиллав. ГХГЗЗГазраас батласан гүйцэтгэлийн төлөвлөгөөний ажлын хүрээнд жил бүрийн 8 дугаар сарын эхний 10 хоногт бэлчээрийн фотомониторингийн ажлыг хийж гүйцэтгэхээр тусгасан байдаг. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.2.1-т заасан ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.</p> <ol style="list-style-type: none"> 1. Шарын гол суманд 2022 оны 08 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд Байгаль орчны мэргэжилтэн Батнасан, бэлчээрийн амуудал хариуцсан мэргэжилтэн Халиун нарын хамт фотомониторингийн 2 цэгт ажиллаж бэлчээрийн ургац тодорхойлж фото зургаар бүрхэцийн мэдээлэл бэлтгэсэн. 2. Хонгор суманд 2022 оны 08 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Газрын даамал Гантуяа , 1 дүгээр багийн засаг дарга Ариунаа нартай хамт фотомониторингийн 6 цэгт ажиллаж бэлчээрийн ургац тодорхойлж фото зургаар бүрхэцийн мэдээлэл бэлтгэсэн. 3. 31 дүгээр хорооллын хаяг зөрүүтэй бичигдсэн 1 иргэний хуучин гэрээ гэрчилгээг авч цахим гэрээ гэрчилгээ үүсгэв. /Г.Сумъяа / 4. 18 иргэний газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлтийг хүлээн авч ГЭЗХХШийдвэрлэх хурлын материал

		<p>бэлдсэн.</p> <p>5. Дөрвөн иргэний газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлтийг хүлээн авч ГЭЗХХШийдвэрлэх хурлын материал бэлдсэн.</p>
2	Газрын кадастрын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудын хийсэн хэмжилтүүдийг хянасан. Үүнд ✓ 5 Иргэний материалыг хүлээн авч 2 иргэний байшинг кадастрын мэдээллийн санд оруулж кадастрын зургийг гаргаж өгсөн. 3 иргэний нэгж талбарыг кадастрын мэдээллийн санд хувааж, өөрчилсөн. ✓ Өмчлөлийн газраа худалдах, өвлүүлэх, бэлэглэх гэрээгээр шилжүүлж байгаа нийт 15 иргэний цахим хүсэлтийг мэдээллийн санд өөрчлөлт хийж, кадастрын зургийг гаргаж өгсөн. ✓ Улсын чанартай авто замын трассаас 2 тийш 50 м зайд орсон, мэдээллийн санд бүртгэлгүй 11 нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. ✓ Дархан сумын Засаг даргын орлогч П.Ихбаяраар ахлуулсан ажлын хэсэгт орж Гэр хорооллын бүсээс мал, туслах аж ахуйг гаргах, зөвшөөрөлгүй буусан 9 малчин өрхөд газар чөлөөлөх шаардах хуудас хүргүүлж ажилласан. ✓ 1 иргэний хүсэлтийн дагуу Геодезийн мэргэжилтний хамт газар дээр нь очиж хяналтын хэмжилт хийсэн.
Захиргаа аж ахуйн чиглэл		
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 0 иргэн /Нүүж өөр өрөөнд орсон тул утасны үзүүр орж ирээгүй тул/, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 7 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. 2022-08-29-ний өдөр АЗДТГ-т болсон e-darkhan цахим хуудас, аппликейшны сургалтанд хамрагдаж, байгууллагын хэрэглэгч үүсгүүлэн, өөрийн мэдээллийг засварлаж, ирсэн 2 хүсэлтийн хариуг өгөв.</p> <p>Мэдээлэл технологийн чиглэлээр: Байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудас, сумдын даамлуудын фэйсбүүк хуудсан дээр 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч буй тухай зар, санал өгөх QR кодыг байрлуулав. 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч буй тухай зарын постерын эхийг сум, аймаг тус бүр дээр хийж, хэвлэж өгөв. E-darkhan цахим хуудасны хэрэглэгчийн ковер фотоны эхийг бэлтгэв. Үндэсийн дата төв рүү цахим хуудасны дискний зай дүүрсэн тул нэмж болох эсэхийг асуусан хүсэлт илгээв. Хонгор сумын газрын даамлын компьютерийн гэмтсэн програмыг засварлаж өгөн, шинэ сканерыг таниулан тохиргоог хийж өгөв.</p> <p>Нярав: Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдээс кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 8 ширхэгийг хүлээж авч бүртгэв. Шаардах хуудсаар 4 төрлийн 16 ширхэг бараа материал олгов. 8-р сарын бараа материал, нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайланг гаргаж ня-бо-д өгөв.</p>

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хянасан:
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах
Г.Нямдорж